



I-VI/2021


Тархаасан: 7 дугаар сарын 09



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 6.6 хувь, өмнөх оны эцсээс 7.0 хувь, өмнөх сараас 0.7 хувиар өссөн байна.

Зураг 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 12.9 хувь (мах, махан бүтээгдэхүүн 18.8 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 7.7 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.8 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 5.5 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 4.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 7.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 16.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 13.8 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 3.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.1 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 3.4 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 0.5 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 0.8 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2021 оны 6 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2021 VI	2021 VI	2021 VI
		2020 VI	2020 XII	2021 V
Ерөнхий индекс	100.0	106.6	107.0	100.7
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	112.9	116.1	101.1
Согтууруулах ундаа, тамхи	4.4	102.9	102.2	100.5
Хувцас, бөс бараа, гутал	16.6	103.3	100.6	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	104.8	113.8	100.1
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	105.0	103.1	100.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	105.2	103.2	100.8
Тээвэр	14.4	104.9	103.0	100.9
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.3	100.2	100.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	101.2	100.4	100.1
Боловсролын үйлчилгээ	4.8	100.8	100.4	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	112.1	110.6	103.5
Бусад бараа, үйлчилгээ	5.4	105.3	102.5	100.3

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 6 дугаар сард 7.2 хувь, 2019 оны 6 дугаар сард 8.3 хувь, 2020 оны 6 дугаар сард 2.8 хувь гарч байсан бол 2021 оны 6 дугаар сард 6.6 хувь болж, өмнөх оны мөн үеэс 3.8 пунктээр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Инфляцад бараа, үйлчилгээний бүлгүүдийн үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 6 дугаар сард

Бараа, үйлчилгээний бүлэг	2018 VI	2019 VI	2020 VI	2021 VI
Ерөнхий индекс	7.2	8.3	2.8	6.6
Хүнсний бараа, ундаа, ус	2.8	2.9	1.4	3.6
Согтууруулах ундаа, тамхи	0.4	0.2	0.2	0.1
Хувцас, бөс бараа, гутал	0.4	1.6	0.7	0.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.3	1.1	0.3	0.5
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.2	0.2	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.4	0.3	0.1	0.2
Тээвэр	0.7	0.7	-1.0	0.6
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.2	0.5	0.0	0.0
Боловсролын үйлчилгээ	0.3	0.3	0.5	0.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.2	0.3	0.2	0.4
Бусад бараа, үйлчилгээ	0.3	0.3	0.2	0.3

Инфляцын түвшин 2021 оны 6 дугаар сард улсын хэмжээнд 6.6 хувь гарсны 3.6 нэгж буюу 54.5 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


Хүснэгт 3. Инфляцад импортын барааны үнийн өсөлтийн оролцоо, нэгжээр, жил бүрийн 6 дугаар сард

Үзүүлэлт	2019 VI		2020 VI		2021 VI	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	8.3	100.0	2.8	100.0	6.6	100.0
Импортын барааны нөлөө	2.9	34.9	0.5	17.9	2.5	37.9

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.


Инфляц 2021 оны 6 дугаар сард 6.6 хувь гарсны 37.9 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 20.0 пунктээр өссөн байна.

Зураг 2. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 6 дугаар сард 5.2 хувиар, 2021 оны 6 дугаар сард 11.6 хувиар өсөж, өсөлтийн хурдац 6.4 пунктээр, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 6 дугаар сард 1.8 хувиар, 2021 оны 6 дугаар сард 4.2 хувиар өсөж, өсөлтийн хурдац 2.4 пунктээр нэмэгджээ.

Зураг 3. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар



Барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 6 дугаар сард 2.5 хувиар, 2021 оны 6 дугаар сард 7.9 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.4 пунктээр нэмэгдэж, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 6 дугаар сард 4.0 хувиар, 2021 оны 6 дугаар сард 2.3 хувиар өсөж, өсөлтийн хурдац 1.7 пунктээр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа, үйлчилгээний бүлгийн үнийн индекс, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 6 дугаар сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2020 VI	Ерөнхий индекс	102.8	102.4	102.7	103.3	103.4	104.3
	Бараа	102.5	102.1	101.5	103.2	103.2	103.9
	Үйлчилгээ	104.0	103.3	107.2	103.5	104.3	106.3
2021 VI	Ерөнхий индекс	106.6	107.1	106.7	104.8	106.4	105.6
	Бараа	107.9	108.7	108.3	105.9	107.8	106.5
	Үйлчилгээ	102.3	103.1	101.1	100.5	100.6	102.1


Хэрэглээний үнийн индексийг бараа, үйлчилгээний бүлгээр авч үзэхэд 2021 оны 6 дугаар сард Улаанбаатар хотод барааны бүлгийн үнэ 8.7 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ Улаанбаатар хотод 3.1 хувиар өссөн нь хамгийн их байна.

Хүснэгт 5. Хүнс, хүнсний бус бүлгийн үнийн индекс, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 6 дугаар сард

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
2020 VI	Ерөнхий индекс	102.8	102.4	102.7	103.3	103.4	104.3
	Хүнс	105.2	104.3	103.2	107.1	107.7	106.0
	Хүнсний бус	101.8	101.5	102.5	101.8	101.5	103.6
2021 VI	Ерөнхий индекс	106.6	107.1	106.7	104.8	106.4	105.6
	Хүнс	111.6	111.5	113.7	110.5	111.6	111.7
	Хүнсний бус	104.2	104.9	104.0	102.5	104.0	103.0

Хэрэглээний үнийн индексийг хүнс, хүнсний бус бүлгээр авч үзэхэд 2021 оны 6 дугаар сард Баруун бүсэд хүнсний бүлгийн үнэ 13.7 хувиар, хүнсний бус бүлгийн үнэ Улаанбаатар хотод 4.9 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн индекс (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 38.0 хувь, өмнөх сараас 3.4 хувиар өслөө. Өмнөх оны мөн үеэс 18.8 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 15.4 хувь, хонины ястай махны үнэ 22.9 хувиар өссөн голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хот:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.9 хувь, өмнөх оны эцсээс 8.4 хувь, өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 13.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 3.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 1.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 6.1 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 14.1 хувь, тээврийн бүлгийн үнэ 6.9 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны эцсээс 8.4 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 16.4 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.4 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 4.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 22.5 хувь, тээврийн бүлгийн үнэ 3.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 1.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 0.6 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 1.4 хувь, тээврийн бүлгийн үнэ 1.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 24.1 хувь буюу 83 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 5.0 хувь буюу 17 бараа, үйлчилгээний үнэ буурч, 70.9 хувь буюу 244 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 47 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 5. Улаанбаатар хотын хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




Зураг 6. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2021 оны 6 дугаар сард 16 622 төгрөг байгаа нь 2018 оны 6 дугаар сараас 57.8 хувь, 2019 оны 6 дугаар сараас 16.8 хувь, 2020 оны 6 дугаар сараас 10.0 хувиар, өмнөх оны эцсээс 32.4 хувь буюу 4071 төгрөг, өмнөх сараас 3.9 хувь буюу 625 төгрөгөөр өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 6 дугаар сард 14 768 төгрөг байгаа нь 2018 оны 6 дугаар сараас 69.1 хувь, 2019 оны 6 дугаар сараас 26.2 хувь, 2020 оны 6 дугаар сараас 16.8 хувиар өссөн, өмнөх оны эцсээс 31.8 хувь буюу 3 560 төгрөг, өмнөх сараас 5.8 хувь буюу 812 төгрөгөөр өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай махны 1 кг дундаж үнэ 2021 оны 6 дугаар сард 12 696 төгрөг байгаа бөгөөд 2018 оны 6 дугаар сараас 69.0 хувь, 2019 оны 6 дугаар сараас 21.7 хувь, 2020 оны 6 дугаар сараас 22.2 хувиар өссөн, өмнөх оны эцсээс 48.0 хувь буюу 4 117 төгрөг, өмнөх сараас 2.5 хувь буюу 307 төгрөгөөр өссөн байна.

Зураг 9. Улаанбаатар хотод худалдаалагдаж буй нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2021 оны 6 дугаар сард 1 450 төгрөг байгаа нь 2018 оны 6 дугаар сараас 16.2 хувь, 2019 оны 6 дугаар сараас 23.1 хувиар буурсан бол, 2020 оны 6 дугаар сараас 4.6 хувь, өмнөх оны эцсээс 1.2 хувь буюу 18 төгрөгөөр өсөж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.


Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 3.7-8.7 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 6 дугаар сард Өвөрхангай аймагт 3.7 хувиар өссөн нь хамгийн бага, Баян-Өлгий аймагт 8.7 хувиар өссөн нь хамгийн их байна.

Зураг 10. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг нийслэлээр, жил бүрийн 6 дугаар сард (өмнөх оны мөн үеэс)



Зураг 11. Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ, жил бүрийн 6 дугаар сард, төгрөгөөр



Аймгуудад 2021 оны 6 дугаар сард худалдаалагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ нь 11494 төгрөг болж, 2020 оны 6 дугаар сараас дунджаар 2232 төгрөг, 2020 оны 12 дугаар сараас 3969 төгрөгөөр их байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 6 дугаар сард Завхан аймагт 9785 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд болон Дундговь аймагт 13000 төгрөг байгаа нь хамгийн их байна.

Ойлголт, тодорхойлолт:

Хэрэглээний сагс: Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин: Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ): Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Тооцох аргачлал:

ХҮИ-ийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейресийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left(\frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left(\frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left(\frac{P_{it}}{P_{i1}} \right) \left(\frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

I_{ct}^L – тайлант үеийн хувиргасан Ласпейресийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

P_{it}^i – i барааны тайлант үеийн үнэ

P_{io}^i – i барааны суурь үеийн үнэ

Q_{io}^i – i барааны суурь үеийн жин

ХҮИ-ийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. ХҮИ-ийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна. Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



Эх үүсвэр: ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

Ангилал, код: ХЗХБҮА

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны ... дугаар сарын ...

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас : (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын статистикч
Д.Батсүх, Т.Жигжидсүрэн
Утас : (976-51)-261561